



ДОРНОД АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

21000, Дорнод аймаг, Хэрлэн сум 7-р баг  
ЗДТГ-ын II байр, Утас/Факс: 7058-4203

2020.08.13 № 515

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

ХАЛХГОЛ СУМЫН ИРГЭДИЙН  
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН СОНГУУЛЬД  
ОРОЛЦОХ ХАЛХГОЛ СУМЫН МАН-ЫН  
ХОРООНЫ ДАРГА Ц.НАСАНХҮҮ ТАНАА

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Орон нутгийн Хурлын сонгуульд оролцох Халхгол сумын Монгол ардын намын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох нам нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хууль болон "Алсын хараа-2050"-д нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцооны хамт ирүүлж, хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох намын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817 - 1 : 2020 Тулгуур зарчим, Төрийн аудит MNS 6817 - 6 : 2020 Нийцлийн аудитын зарчим, Төрийн аудит MNS 6817 - 8 : 2020 Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2020 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2020-2022 оны төсвийн төсөөллийн тухай хууль болон "Алсын хараа-2050", холбогдох бусад байгууллагаас авсан мэдээллийг шалгуур болгосон.

Дүгнэлт

"Халхгол сумын МАН"-ын сумын Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөр, түүнд орсон зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3. дахь хэсэг, "Алсын хараа-2050", Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

"Халхгол сумын МАН"-ын мөрийн хөтөлбөр /.../ хуудас/-ийг хавсаргав.

Хувийг: Дорнод аймгийн сонгуулийн хороонд

Хавсралт /.../ хуудастай.

ДАРГА БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Б.БОЛОРТУУЛ



011020613



# МОНГОЛ АРДЫН НАМ



ДОРНОД АЙМАГ ХАЛХГОЛ СУМ  
МОНГОЛ АРДЫН НАМЫН МЭРИЙН ХӨТӨЛБӨР.

2020 он




## СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН 2020 ОНЫ СОНГУУЛЬД ОРОЛЦОХ ХАЛХГОЛ СУМЫН МОНГОЛ АРДЫН НАМЫН МӨРИЙН ХӨТӨЛБӨР

**Зорилго:** Наран ургах хязгаар нутаг, Халхгол сумын иргэд нь ажилтай, орлоготой, хүүхэд, залуучууд нь эрүүл чийрэг, эрдэм боловсролтой, ахмад буурлууд нь аз жаргалтай, эрүүл аюулгүй тайван орчинд амьдарч, хүний хөгжлийн шалгуур үзүүлэлтийг сайжруулсан Улсдаа Тэргүүлсэн **ЖИШИГ СУМ** болно.

**Уриа: ХАЛХГОЛ СУМЫНХАА ТӨЛӨӨ  
ХҮЧЭЭ НЭГТГЭН - ЗҮТГЭЕ**

**Мөрийн хөтөлбөр хэрэгжих хугацаа: 2020-2024 он**



### НЭГ. ТӨРИЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД:

#### 1.1.Төрийн бодлогыг хэрэгжүүлэх зорилтын хүрээнд:

- 1.1.1 Нийт төрийн болон төрийн өмчит аж ахуй нэгж, байгууллагын менежментийн чадавхийг бэхжүүлж, Олон улсын жишигт нийцсэн чанарын удирдлагын ISO-9001 тогтолцоог нэвтрүүлнэ.
- 1.1.2 Хүүхэд, залуучуудад эх оронч үзлийг төлөвшүүлэх, сурталчлан таниулах ажлыг зохион байгуулна.
- 1.1.3 Мэдлэг чадвар, туршлагатай ахмад мэргэжилтэн бүхий зөвлөхүүдийн холбоог байгуулж, дунд болон залуу үедээ зөвлөгөө, туршлагаасаа хуваалцах бололцоог бүрдүүлнэ.
- 1.1.4 Төрийн байгууллагуудын үйл ажиллагааг нээлттэй, ил тод байдлаар иргэдэд шуурхай хүргэж, төрийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлнэ.
- 1.1.5 Төрийн үйлчилгээг нэг цэгт төвлөрүүлж иргэдийг төрийн үйлчилгээнд чирэгдэлгүй үйлчлүүлэх боломжийг бүрдүүлнэ.
- 1.1.6 Монгол Улсын Авлигын эсрэг хууль тогтоомжуудыг чанд мөрдөж ашиг сонирхолын зөрчлөөс ангид ажиллана.
- 1.1.7 Төрийн албан хаагчдыг орон сууцаар хангах ажлыг зохион байгуулна.
- 1.1.8 Хөрш зэргэлдээ орны аймаг, хоттой байгуулсан уламжлалт найрсаг харилцааг бэхжүүлж талуудын хамтын ажиллагааг нийгэм, эдийн засаг хүмүүнлэг, дэд бүтцийн салбарт өргөжүүлэн хөгжүүлнэ.
- 1.1.9 Олон улсын байгууллага, төсөл хөтөлбөрүүдийг дэмжиж хамтран ажиллана.
- 1.1.10 Хил хамгаалах туслах хүчний үйл ажиллагааг эрчимжүүлж, хил хамгаалах байгууллагын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж ажиллана.

## ХОЁР. НИЙГМИЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД:

### 2.1. Эрүүл мэндийн салбарын чанар, хүртээмжийг сайжруулах бодлогын хүрээнд:

- 2.1.1 Сумын эрүүл мэндийн үйлчилгээг стандартын түвшинд хүргэнэ.
- 2.1.2 Ерөнхий боловсролын сургууль болон сургуулийн өмнөх боловсрол олгох байгууллагуудыг эмчээр хангаж, сурагчдын эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлнэ.
- 2.1.3 Нарийн мэргэжлийн эмч, эрүүл мэндийн ажилтнуудыг бэлтгэх, сургах, мэргэшүүлэх хөтөлбөрийг үндэсний их, дээд сургуулиудтай гэрээ байгуулан хэрэгжүүлж эрүүл мэндийн салбарын хүний нөөцийг чадавхжуулна.
- 2.1.4 Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх эрт илрүүлгийн үзлэг оношлогоог эрчимжүүлэн халдварт өвчнийг бууруулах ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.
- 2.1.5 Халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлгийн үзлэг оношилгоо, сургалт, сурталчилгааны ажлыг эрчимжүүлэн жил бүр үр дүнтэй зохион байгуулж эрүүл аж төрөх зан үйлийг хэвшүүлэх ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.
- 2.1.6 Монгол улсын Засгийн газар, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас баталсан үндэсний болон дэд хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж иргэдийн нийгмийн эрүүл мэндийн мэдлэг, эрүүл аж төрөх ёсны мэдлэгийг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулна.
- 2.1.7 Сумын Эрүүл мэндийн төвийн зайлшгүй шаардлагатай тоног төхөөрөмжийн хангалтыг нэмэгдүүлж оношлогоо эмчилгээний чадавхыг сайжруулна.
- 2.1.8 Алслагдсан айл өрх, хилийн сумангуудын иргэдэд нийгмийн эрүүл мэндийн болон эрүүл мэндийн тусламж үйлчилгээг улирал тутамд чанартай хүргэх ажлыг зохион байгуулна.
- 2.1.9 Ялалт багийн эмнэлгийн ажиллах нөхцөл бололцоог сайжруулж иргэдэд хүрэх хүртээмжийг нэмэгдүүлнэ.

### 2.2 Боловсрол, соёл, спортын чанар хүртээмжийг сайжруулах зорилтын хүрээнд:

- 2.2.1. Боловсрол, соёл, урлагийн байгууллагыг интернетийн шилэн кабельд бүрэн холбож, цахим номын сан, мэдээллийн сантай болгоно.
- 2.2.2 Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн үйл ажиллагааг чанаржуулж, багш нарыг чадавхжуулна.
- 2.2.3 Сургууль, дотуур байр, цэцэрлэгийн орчныг сайжруулна.
- 2.2.4 Суманд нэн шаардлагатай багш, боловсон хүчний тав тухтай амьдрах нөхцөлийг хангах ажлыг зохион байгуулна .
- 2.2.5 Хүүхдийн урлагийн “Халхгол” чуулгыг сэргээн хөгжүүлнэ.
- 2.2.6 Элсэлтийн ерөнхий шалгалт, олимпиадад амжилт үзүүлсэн багш, сурагчдыг урамшуулна.
- 2.2.7 Улс болон бүс, аймгийн чанартай тэмцээн, уралдаанд амжилт гаргасан тамирчдыг урамшуулна.
- 2.2.8 Нийтийн биеийн тамирыг хөгжүүлнэ.

- 2.2.9 Улс, аймаг, бүсийн чанартай урлаг, соёл, спортын тэмцээн, уралдаанд оролцоход бүх талаар дэмжинэ.
- 2.2.10 Сургууль, цэцэрлэгийн хүүхэд, багш, ажилчдад нийтийн тээврийн унаагаар үйлчилнэ.
- 2.2.11 Их бурхант цогцолборын Тахилын сүмийг сэргээн байгуулахыг бодлогоор дэмжиж ажиллана.
- 2.2.12 Хүүхэд залуучуудын чөлөөт цагийг өнгөрүүлэх соёл, спортын төвтэй болно.
- 2.2.13 Монгол Улсын Засгийн газар, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас баталсан соёлын хөтөлбөрүүдийг орон нутагт хэрэгжүүлж ажиллана.
- 2.2.14 Үндэсний спортыг хөгжүүлэхэд дэмжиж ажиллана.
- 2.2.15 Дотуур байранд эцэг, эх, сурагчдын уулзалт амралтын өрөөг тохижуулна.
- 2.2.16 Соёлын төвийн иргэдэд хүргэх үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлнэ.
- 2.2.17 Төрийн албан хаагчдын 1-2 хүртэлх насны хүүхдийг харах ясли байгуулах ажлыг эхлүүлнэ.
- 2.2.18 Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн сургалт хийх, мэргэшсэн багшийг бэлтгэж, чадавхжуулах.
- 2.2.19. Орон нутгийн түүх, соёлын дурсгал судлах ажлыг зохион байгуулж, орон нутаг судлах кабинет тохижуулна.
- 2.2.20 Өсвөр насны хүүхдийг амьдрах ухаанд сургаж төлөвшүүлэх зорилготой хөдөлмөр амралтын зуслан байгуулах ажлыг үе шаттай хэрэгжүүлнэ.

## **ГУРАВ. ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД:**

### **3.1. Иргэдийн амьжиргааны түвшинг дээшлүүлэх зорилтын хүрээнд:**

- 3.1.1 Төмс хүнсний ногооны тариалалтыг нийт өрхийн 30 хувьд хүргэж сумын төмс хүнсний ногооны хэрэгцээг бүрэн хангана.
- 3.1.2 Жимс, жимсгэнэ тариалах, өрхийн жижиг бизнес эрхлэхэд онцгой анхаарч ажиллана.
- 3.1.3 Малжуулах төслийг илүү боловсронгуй болгон хэрэгжүүлнэ.
- 3.1.4 Баг бүрт жижиг, дунд үйлдвэрлэл байгуулах санал санаачлагыг дэмжинэ
- 3.1.5 Суманд талх, нарийн боов, сүү цагаан идээ, мах махан бүтээгдэхүүн боловсруулдаг жижиг үйлдвэр, цехийг зах зээлийн хэрэгцээнд нийцүүлэн оновчтой хэлбэрээр байгуулан ажиллахыг дэмжинэ.
- 3.1.6 Сумын ахуй үйлчилгээний газрыг зориулалтын дагуу ажиллуулна.
- 3.1.7 Буйр нуурын загасны аж ахуйг сэргээх ажлыг бодлогоор дэмжинэ.
- 3.1.8 "Өрх бүрт- нэг ажлын байр" хөтөлбөр хэрэгжүүлнэ.
- 3.1.9 Халхголын бренд бүтээгдэхүүн зөгийн балны савлагаа, хаяг шошгийг олон улсын стандартад хүргэх ажилд дэмжлэг үзүүлнэ.
- 3.1.10 Сумын жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн бүтээгдэхүүнийг улс, аймаг, олон улсын үзэсгэлэн худалдаанд оролцуулж бизнесийг өргөжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.
- 3.1.11 Залуу гэр бүлийг дэмжих зорилгоор инженерийн шугам сүлжээнд холбогдсон амины орон сууцны хорооллыг байгуулахад дэмжлэг үзүүлнэ.

- 3.1.12 Хөгжлийн бэрхшээлтэй иргэд, ахмадуудын хөдөлмөр эрхлэлт, бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг бодлогоор дэмжиж ажиллана.
- 3.1.13 Залуу гэр бүлийг дэмжих хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлж ажиллана.

**3.2 Хөдөө аж ахуйг хөгжүүлэх, бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжих зорилтын хүрээнд:**

- 3.2.1 Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас баталсан “Газар тариалангийн үйлдвэрлэлийн талаар баримтлах бодлого”-ыг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.
- 3.2.2 Халхголын хөрсөнд ургуулсан улаан буудайгаар эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэн орон нутгийн иргэдийн хэрэгцээг хангаж, экспортод гаргахыг бодлогоор дэмжинэ.
- 3.2.3 Тариалангийн талбайн хөрсний элэгдлээс урьдчилан сэргийлэх зорилгоор зурваслан мод тарих ажлыг үе шаттайгаар зохион байгуулна.
- 3.2.4 Хөдөө аж ахуйн чиглэлээр үйлдвэрлэл эрхэлж буй аж ахуй нэгжүүдтэй нийгмийн хариуцлагын гэрээ байгуулж, хамтын ажиллагааг шинэ шатанд гарган орон нутагт орох үр өгөөжийг нэмэгдүүлнэ.
- 3.2.5 Бэлчээрийн болон хагас эрчимжсэн мал аж ахуйг хослуулан хөгжүүлж, Дорнод талын мухар улаан үүлдрийн үхрээр цөм сүрэг үүсгэн нутгийн брэнд бий болгоно.
- 3.2.6 Бэлчээрийн усан хангамжийг нэмэгдүүлж шаардлагатай цэгт инженерийн шийдэлтэй худаг байгуулна.
- 3.2.7 Хоршоо, фермерийн аж ахуйг хөгжүүлнэ.
- 3.2.8 Малчдын нийгмийн баталгааг хангах, залуучууд, залуу гэр бүлийг мал аж ахуйн салбарт ажиллах боломж нөхцлийг бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.
- 3.2.9 Мал эмнэлэг, малын эмчийн чадавхийг сайжруулахад дэмжлэг үзүүлнэ.
- 3.2.10 Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас баталсан “Тэмээ дэд хөтөлбөр”, “Мал хулгайлах гэмт хэргээс урьдчилсан сэргийлэх” хөтөлбөрүүдийг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.
- 3.2.11 Сумын хэмжээнд доройтсон бэлчээрийг үе шаттайгаар чөлөөлөх ажлыг зохион байгуулж, бэлчээрийн нөхөн сэргээх боломжийг бүрдүүлнэ.
- 3.2.12 Малын гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх ажлыг сайжруулж, эрүүл бүс болгоно.
- 3.2.13 Хадлан, тэжээл зохистой бэлтгэж эдийн засгийн эргэлтэд оруулна.

**ДӨРӨВ. БАЙГАЛЬ ОРЧИН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫГ ХӨГЖҮҮЛЭХ БОДЛОГЫН ХҮРЭЭНД:**

**4.1 Байгаль орчныг сайжруулах зорилтын хүрээнд:**

- 4.1.1 Сумын төвийн ногоон байгууламжийг нэмэгдүүлнэ.
- 4.1.2 Газрын тос, уул уурхай, хайгуул, олборлолтын компаниудын үйл ажиллагаанд байнгын хяналт-шалгалт хийж, орчны бохирдлоос сэргийлнэ.
- 4.1.3 Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас баталсан “Ой, хээрийн түймрээс урьдчилсан сэргийлэх, түүнтэй тэмцэх бодлого”-ыг үргэлжлүүлж хэрэгжүүлнэ.
- 4.1.4 Хог хаягдлын менежментийг сайжруулж цэвэр орчныг бүрдүүлнэ.

- 4.1.5 Халхголын эрэг дагуух модыг хамгаалах ажлыг үе шаттай зохион байгуулна.
- 4.1.6 Буйр нуурын эрэг дагуух элсний нүүдлийг багасгах зорилгоор ойн зурвас байгуулах ажлыг бүх талаар дэмжин ажиллана.
- 4.1.7 Байгаль орчны эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлж ажиллана.
- 4.1.8 Сумын нутаг дэвсгэр дэх ургамлын бүтэц, төрөл зүйлийн нарийвчилсан судалгааг мэргэжлийн байгууллагаар хийлгэнэ.


#### 4.2 Аялал, жуулчлалыг дэмжих зорилтын хүрээнд:

- 4.2.1 Хүүхдийн овоо, Их бурхант цогцолборыг түшиглэсэн аялал жуулчлалын арга хэмжээг жил бүр зохион байгуулна.
- 4.2.2 Сумын байгалийн түүхийн үзмэрийн нөөцөд түшиглэн эко аяллын хөтөлбөр, маршрут боловсруулж төр, хувийн хэвшлийн оролцоотой хэрэгжүүлнэ.
- 4.2.3 Нутгийн иргэдийг түшиглэн аялал жуулчлалыг явуулж өрхийн орлогыг нэмэгдүүлнэ.
- 4.2.4 Хил орчмын аялал, жуулчлалыг хөгжүүлэхийг дэмжиж ажиллана.
- 4.2.5 Авто замын тэмдэг, тэмдэглэгээ, мэдээлэх самбар байрлуулах ажлыг зохион байгуулж, авто замын аюулгүй байдлыг хангана.
- 4.2.6 Аялал жуулчлалд зориулсан бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжинэ.
- 4.2.7 Орон нутагт аялал жуулчлал эрхэлж буй аж нэгжүүдийн үйл ажиллагааг стандартын түвшинд хүргэж эрүүл ахуйн шаардлагад нийцүүлнэ.
- 4.2.8 Спорт ан агнуурын жуулчлалыг хөгжүүлэхийг дэмжиж ажиллана.
- 4.2.9 Буйр нуурт усан аялал жуулчлалыг хөгжүүлэх ажлыг дэмжинэ.

#### ТАВ. ДЭД БҮТЭЦ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН АЖЛЫН ХҮРЭЭНД:

- 5.1 Хувийн орон сууц барих иргэн, аж, ахуй нэгжид газар олголт, инженерийн шугам сүлжээнд холбох ажлыг дэмжиж ажиллана.
- 5.2 Сумын төвийн нийтийн эзэмшлийн орон сууцны цэвэр ус, бохир ус, дулааны шугам сүлжээний ажлыг үргэлжлүүлэн хийнэ.
- 5.3 Сумын төвийн үер уснаас хамгаалах далан шуудууг сэргээн засварлуулах ажлыг зохион байгуулна.
- 5.4 Сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний дагуу шинээр баригдсан төсвийн байгууллагаас төв зам хүртэлх иж бүрэн хатуу хучилттай 277 метр зам барьж байгуулна.
- 5.5 Сумын төв, Ялалт багийг интернетийн шилэн кабельд холбох ажлыг санаачилна.
- 5.6 Халхгол-Чойбалсан хүртэл хатуу хучилттай зам тавих ажлыг эхлүүлнэ.
- 5.7 Сумын төв, Ялалт баг, Буйр тосгоны гэрэлтүүлгийг шинэчилж сайжруулна.
- 5.8 Гэр хорооллын айл өрхийг эгнээжүүлэн, стандартад нийцсэн хаягтай болгож, хашааны өнгө үзэмжийг сайжруулна.
- 5.9 Захын гэр хорооллын цахилгаан хангамжийг сайжруулах, өргөтгөх, нэмэлт цахилгаан дамжуулах шугам татна.
- 5.10 Хамардаваа, сумын төвийн зам засвар, тохижилтын ажлыг хийнэ.

- 5.11 Суманд агаарын тээврийн үйлчилгээг нэвтрүүлж, нисэх буудал байгуулах ажлыг эхлүүлнэ.
- 5.12 Алслагдсан багийн иргэдийн холбоо мэдээллийг сайжруулна.
- 5.13 Сумын төвөөс Сүмбэр боомт хүртэлх замыг сайжруулж хатуу хучилттай зам барих ажлыг эхлүүлнэ.
- 5.14 Наадмын талбайг барьж байгуулна.
- 5.15 “Халхгол нэгдэл” ОНӨААТҮГазрын үйл ажиллагааг өргөжүүлж, дэмжлэг үзүүлнэ.
- 5.16 Хүүхдийн парк барих ажлыг бодлогоор дэмжин ажиллана.
- 5.17 Суманд бүтээгдэхүүн худалдаалах бөөний төв байгуулахыг бодлогоор дэмжинэ.



**ЗУРГАА. ГАМШГААС ХАМГААЛАХ, УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ  
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХҮРЭЭНД:**

- 6.1 Ой, хээрийн түймэр, ахуйн осол гэмтэл, үер ус, байгалийн гамшгаас урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлнэ.
- 6.2 Сумын мэргэжлийн ангийн ажиллах нөхцөл бололцоо, тоног төхөөрөмжөөр ханган ажиллана.
- 6.3 Онцгой байдлын ангийн албан хаагчдын ажиллах, амьдрах орчин нөхцлийг бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлж ажиллана.